



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар A/9

Мандалговь

Г А.Ганцээгийг Байгаль орчин, аялал
Жуулчлалын газрын Орчны бохирдол, химиин хорт
бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт,
дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Орчны бохирдол, химиин хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Алтангэрэл овогтой Ганцэцэг 73.8 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа А.Ганцээгийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2023 оны дугаар сарын
.....-ны өдрийн дугаар тогтоолын хавсралт



**Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Орчны бохирдол,
химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт,
дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлсэн А.Ганцэцэгийн тухай дүгнэлт**

1. А.Ганцэцэг нь 1987 онд Ховд аймгийн Булган суманд төрсөн. 36 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2005-2009 онд ХААИС-ийг ургамал хамгаалал, хорио цээрийн шинжээч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн. 2019-2021 онд ОУУБИС-ийг магистр зэрэгтэй гэр бүл судлаачаар төгссөн.
3. 2010-2019 онд Өмнөговь аймгийн Шивээ хүрэн боомтод ургамал хорио цээрийн улсын байцаагч, 2019-2023 онд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт архив бичиг хэрэг, ахлах арга зүйч, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн тус тус ажиллаж байсан.
4. А.Ганцэцэгийн төрийн албаны дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Орчны бохирдол, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ